



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 230


Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 36.1 тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбурхан өвчний хөнгөн, дунд хэлбэрийг оношилох, эмчлэх зааврыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Зааврыг хэрэгжүүлж ажиллахыг аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Баяр/-т даалгасугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080786

Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 06 сарын 05 өдрийн  
230 дугаар тушаалын хавсралт

## УЛААНБУРХАН ӨВЧНИЙ ХӨНГӨН, ДУНД ХЭЛБЭРИЙГ ОНОШИЛОХ, ЭМЧЛЭХ ЗААВАР

### Нийтлэг үндэслэл:

Монгол улсад 2009 оноос хойш улаанбурхан өвчин бүртгэгдэлгүй 2015 оны 3 дугаар сарын 18-нд лабораториор батлагдсан 3 тохиолдол оношлогдсоноос хойш улаанбурхан өвчний 12458 сэжигтэй тохиолдол бүртгэгдэж, өнөөгийн байдлаар 540 хүний онош батлагдаж, 1984 хүн тархвар судлал, эмнэлзүйн шинж тэмдгээр тус тус тогтоогдлоо.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний ачаалал нэмэгдсэнтэй холбогдуулан тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах, аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг, өрх, сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн эмч нарт мэргэжил аргагүйн дэмжлэг үзүүлэхэд энэхүү зааврын зорилго оршино.

### Тодорхойлолт:

Улаанбурхан нь ерөнхий хордлогын шинж, өндөр халууралт, амьсгалын дээд зам болон нүдний салст бүрхэвчийн үрэвсэл, арьсны толбот гүвдрүүт тууралт нүүр, чихний араас эхлэн дээрээс доош шаталж гарах шинжүүдээр илэрдэг цочмог халдварт өвчин юм.

### Үүсгэгч:

Улаанбурханы үүсгэгч вирус нь morbillivirus-ийн удмын paramyxoviridae бүлгийн 120-230 нм хэмжээтэй бөөрөнхий хэлбэртэй, дан эрчилсэн РНХ агуулсан вирус

### Тархвар судлал:


- Халдварын эх уурхай: Улаанбурхан өвчнөөр өвчилсөн хүн.
- Дамжих зам: Уг халдвараар өвчилсөн хүний ханиах найтаах, ярих үед вирус нь шүлс, цэрний хамт гадаад орчинд цацагдан, агаар дуслын замаар болон халдвартай хүний цэр, шүлсээр халдварлана.
- Халдварлалтын индекс 96%, Улаан бурхнаар өвчлөөгүй буюу үр дүнтэй дархлаажуулалт хийлгээгүй бүх хүмүүс уг өвчнөөр өвдөх эрсдэлтэй.
- Өвөл, хаврын улиралд өвчлөл ихсэж, 8-10 жилийн үечлэлтэй дэгдэнэ.
- Өвчилсний дараа тогтвортой дархлаа тогтоно.
- Халдвартай байх үе: Өвчний урьтал үе эхлэхээс 1 хоногийн өмнөөс (гол төлөв тууралт гарч эхлэхээс 4 хоногийн өмнөөс) тууралт гарснаас хойш 4 хоног өнгөрөх хүртэлх хугацаанд халдвартай байна.

### Өртөмтгий байдал

Улаанбурхан өвчнөө урьд өвдөж байгаагүй, заавал хийх дархлаажуулалтын үндэсний товллын дагуу дархлаажуулалтанд хамрагдаагүй бүх насны хүн халдварт өртөж болно. Өвчилсөний дараа насан туршийн дархлаа тогтоно.

## **Тархвар судлалын тандалт**

Тандалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, голомтод авах халдвар эсэргүүцэх арга хэмжээг авч, мэдээ цуглуулах, дүн шинжилгээ хийх, мэдээлэх үйл ажиллагааг тогтмолжуулж ажиллах.



## **Эмнэл зүйн үе шат:**

Нууц үе, урьтал буюу улаймал үрэвслийн үе, тууралтын үе, эдгэрэх үе гэсэн 4 үндсэн үе шатуудаар эмнэлзүй нь илэрнэ.

## **Нууц үе:**

Дунджаар 10-12 хоног бөгөөд богино хугацаа нь 7, урт хугацаа нь 28 хоног хүртэл байж болно.

## **Улаймал үрэвслийн үе /3-4 хоног/**

- Ерөнхий хордлогын хам шинж: Халуурах, хоолонд дургүйцэх, сульдах, бага насны хүүхэд тайван бус болох,
- Амьсгалын замын үрэвслийн хам шинж: Хамар битүүрэх, хамраас усархаг шингэн нус гоожиж, хуурай ханиах,
- Нүдний салст бүрхүүлийн үрэвслийн хам шинж: Нүдний салст улайх, зовхи хавагнах, нулимс гоожих, сүүлдээ нуухтах, гэрэлд гялбах, доод зовхи хөхөрч хавагнах,
- Салстын тууралтын хам шинж:
  1. Бельский-Филатов-Копликийн толбо -Амны хөндийн салс ялангуяа бага арааны ойролцоох жавьжинд улаан хүрээтэй, жижигхэн, хусахад арилахгүй, цагаан буюу цагаан цэнхэр туяатай толбо туурна,
  2. Германы толбо: Гүйлсэн булчирхайд цайвар өнгөр тогтох,
  3. Петены тууралт: Зөөлөн тагнайд жижиг цусан тууралт туурна.

## **Тууралтын үе:**

Хамгийн түрүүнд нүүрнээс эхлэн өвөрмөц толбот-гүвдрүүт тууралт гарч эхлэх бөгөөд энэ тууралт чихний араас эхлэн дээрээсээ доошилсоор сүүлдээ бүх биеэр гарч, 4-7 хоног үргэлжилнэ. Тууралт нь тод улаан өнгөтэй, том, хоорондоо нийлсэн барсгар, тууралт хоорондын завсарын арьс нь хэвийн өнгөтэй байдгаас улаан цоохор харагдана. Энэ үед тууралт болон эмнэлзүйн шинж тэмдгүүд илэрнэ:

- Зовхи, хамар уруулын салст хөөнгөтөж хавагнах,
- Нүд гэрэлд гялбах,
- Булчингаар өвдөх,
- Нүдний салст бүрхэвч хавагнах, улайх, нулимс гоожих, нуух цувах, (Коньюктивит)
- Хамраас эхэндээ шингэн, яваандаа идээрхүү ногоон өнгөтэй нус гарах,
- Ханиах нь зовиуртай, олон удаа, хуурай цэр багатай байх,
- Хоолой сөөнгөтөх шинж тэмдгүүд илэрнэ.

**Эдгэрэх үе:**

Эмнэлзүйн шинж тэмдгүүд болон тууралт арилна. Тууралт нь ялимгүй хогжруутан гуужиж байгаад хүрэн бор өнгийн нөсөө үлдээнэ.

**Эмнэлзүйн хэлбэр:**

**Хөнгөн** : Тууралт их биш, хордлогын шинж тэмдэг байхгүй эсвэл бүдэг, халуурах биеийн хэм 38,0—38,5° аас ихгүй, хөлрөх, улайралтын шинж тэмдэг сул илэрсэн.

**Дунд** : Тууралт их, хордлогын шинж тод илэрсэн (биеийн халуун 39,0 ° ба түүнээс дээш, бөөлжих шинж илэрнэ), амьсгалын дээд замын улайх шинж тод илэрдэг, нүүр хавагнасан, хуурай ханиалга ихтэй.

**Хүнд** : Хордлого - маш их (40°C ба түүнээс дээш, татах, ухаан алдах, олон дахин бөөлжих), амьсгалын болон бусад эрхтэн системийн талаас хүндрэлүүд гардаг.

**Дархлаажуулалтын дараах улаанбурхан (Хөнгөрүүлсэн) :**

Дархлаажуулалтанд хамрагдсан, өвчин нууц үедээ байхад гаммаглобулин тариулсан хүмүүст илэрнэ. Энэ хэлбэр нь хөнгөн явагдах ба дараах онцлогтой. Үүнд: Нууц үе нь урт /21-28/ хоног, эхлэл үе богино (1-2) хоног, Копликийн толбо илрэхгүй, улайралтын шинжүүд сул, халуун их биш эсвэл хэвийн, тууралтын үргэлжлэх хугацаа богино. Нэг өдрийн дотор шат дараалалгүй туурах ба элемент нь цөөхөн, бүдэг, хоорондоо нийлдэггүй, нөсөөжилт нь бүдэг, 1 долоо хоногоос хэтрэхгүй арилна. Гуужилт байхгүй.

**Оношилгоо:**

Өвчтөнөөс асууж шинжлэх явцдаа улаанбурхан байж болзошгүйг харуулж буй шинжүүдийг тодруулна.

1. Халдвар судлалын асуумж,
2. Эмнэлзүйн шинж тэмдэг,
3. Халдварын эхэн үед цусанд лейкопени, лимфоцитоз илэрдэг ба нянгийн халдвараар хүндэрсэн тохиолдолд лейкоцитоз, нейтрофилоз болдог.

**Эмчилгээ:**

Хөнгөн, дунд хэлбэрийн өвчлөлийн үед өрх, сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн эмч, аймаг дүүргийн нэгдсэн эмнэлгийн халдвартын эмчийн зөвлөгөөгөөр гэрээр эмчилнэ. Энэ эмчилгээний үед гэрийн нөхцөлд тусгаарлан, чанартай хоол өгч, халуун бүлээн шингэн уулган, шинж тэмдгийн эмчилгээ хийнэ.

**Витамин А-гийн урьдчилан сэргийлэх болон эмчилгээний тун:**

Өвчний хүндрэлээс сэргийлэх (Нүдний хүндрэл)

- Нярай < 6 сар: витамин А 50,000 IU/өдөрт уухаар хоногт 1 удаа өнжөөд 2 хоног
- 6-12 сар : витамин А 100,000 IU/өдөрт уухаар хоногт 1 удаа өнжөөд 2 хоног
- ≥ 1нас : витамин А 200,000 IU/өдөрт хоногт 1 удаа өнжөөд 2 хоног

#### Дархлаа дэмжих зорилгоор:

- Гроприносин 1-ээс дээш насны хүүхдэд 50-100 мг/кг-аар, насанд хүрэгчдэд 1-2 шахмалаар хоногийн тунг 3-4 хувааж 7-10 хоног амаар уулгах,
- Виферон: 1 хүртэлх насны хүүхдэд 150000 Ед-р өдөрт 1-2 удаа 7 хоног, 1-2 насанд 500000 Ед-р өдөрт 1-2 удаа, насанд хүрэгчдэд 3 сая Ед-р өдөрт 1-2 шулуун гэдсээр хийх,
- Циклоферон: насанд хүрэгсэд 450-600 мг-аар хоногт нэг удаа, өнжөөд уух буюу долоо хоногт 3 удаа, хүүхдэд хоногт 6-10 мг/кг-аар тооцож, өнжөөд уух буюу долоо хоногт 3 удаа, нийтдээ 12 удаа хэрэглэх.

#### Халуун бууруулах зорилгоор:

Парацетамол, Ибупрофен, Диклофенакийг зохих тунгаар

#### Бөөлжилттэй үед

Метоклопромид 0.5-1 мг/кг-аар булчинд болон судсанд тарих

#### Суулгалтын шинж, тэмдэг илэрсэн үед

Амаар хорсол болон шингэн сэлбэх зорилгоор уулгах.

#### **Хүндрэл**

Өвчний хүнд хэлбэрийн үед эмнэлэгт хэвтүүлж эмчилнэ.

#### **Зонхилон тохиолдох хүндрэл:**

- Дунд чихний үрэвсэл,
- Уушгины завсрын эдийн хатгаа,
- Бронхопневмони,
- Ларинготрахеибронхит,
- Суулгалт.

#### **Ховор тохиолдох хүндрэл:**

- Энцефалит,
- Панэнцефалит,
- Тромбоцитопени,
- Аппендицит,
- Миокардит,
- Перикардит,
- Панкреатит:

#### **Ялган оношилгоо:**

Улаанууд, улаан эсэргэнэ, хуурамч сүрьеэ, иерсиниоз, энтеровируст халдвар, халдварт моноклеоз, ийлдсийн өвчин, харшлын болон эмийн шалтгаант тууралт, коксаки, ЕСНО зэрэг вируст халдвараас ялган оношилно.